



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ
ТЭМДЭГЛЭЛЭЭС**

2024 оны 12 сарын 30 өдөр

Дугаар 29

Улаанбаатар хот

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн хуралдааны 32 дугаар тэмдэглэлд:

32.52.ХЭЛЭЛЦСЭН нь:

“Үндэсний шигшээ багийн бэлтгэл, сургалтын төв” төрийн өмчит үйлдвэрийн газарт хяналт шалгалтыг зогсоосон тухай

ШИЙДВЭРЛЭСЭН нь:

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 66 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 7.4 дэх хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас 2024 онд төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд хяналт шалгалт хэрэгжүүлэх төлөвлөгөө, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын баталсан 2024 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 24-01/09 дугаартай хяналт шалгалтын удирдамжийн дагуу “Үндэсний шигшээ багийн бэлтгэл, сургалтын төв” төрийн өмчит үйлдвэрийн газарт хяналт шалгалт хэрэгжүүлэх ажлын хэсэг байгуулагдан ажилласан.

Хяналт шалгалт эхлэх талаар 2024 оны 12 дугаар сарын 06-ны өдөр 15:46 цагт төрийн өмчит үйлдвэрийн газрын Захиргаа, санхүүгийн албаны дарга Э.Мөнхболдтой 88102729 дугаар утсаар ярьж урьдчилан мэдэгдсэн.

Шалгалтын удирдамжийг 2024 оны 12 дугаар сарын 09-ний өдөр тус үйлдвэрийн газрын захирал Б.Наран-Идэрт танилцуулсан бөгөөд бэлтгэх материалын жагсаалтыг файлаар хүргүүлсэн.

Үйлдвэрийн газрын Захирал Б.Наран-Идэр нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас ээлжийн амралт эдлэх тухай зохих зөвшөөрөлгүй гадаад улсад зорчсон, Ерөнхий менежер Ц.Одонбаяр нь хяналт шалгалтын явцад холбогдох баримт, бичгийн бүрдэлд хяналт тавьж ажиллах үүргээ биелүүлээгүй, Захиргаа, санхүүгийн албаны дарга Э.Мөнхболд нь байгууллагын Хөдөлмөрийн дотоод журмын дагуу хүсэлт гаргаагүй байхад захирлын тушаалаар шалгалт эхэлсэн өдрөөс буюу 2024 оны 12 дугаар сарын 09-ний өдрөөс 12 дугаар сарын 17-ны өдөр дуустал чөлөөтэй, ХБНГУ-д зорчсон бөгөөд “Үндэсний шигшээ багийн бэлтгэл, сургалтын төв” төрийн өмчит үйлдвэрийн газар нь хяналт шалгалтад шаардлагатай баримт материалыг 2024 оны 12 дугаар сарын 17-ны өдөр хүртэл ажлын хэсэгт бэлтгэх материалын жагсаалтын дагуу бүрэн гаргаж өгөөгүй, ирүүлсэн баримт материал нь баримтын иж бүрэн шалгалт хийх шаардлага хангахгүй, нягтлан шалгаж, тулган баталгаажуулах боломжгүй байсан тул хяналт шалгалт хэрэгжүүлэхэд саад учруулсан гэж ажлын хэсэг дүгнэсэн бөгөөд үйлдвэрийн газрын удирдлага болон бусад албан тушаалтан нарт танилцуулж “Хяналт шалгалтыг

зогсоох тухай” тэмдэглэлд гарын үсэг зурж зөвшөөрснөөр хяналт шалгалтыг үргэлжлүүлэн хэрэгжүүлэхийг зогсоосон болно.

Үйлдвэрийн газраас ирүүлсэн баримт материал нь Сангийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 347 дугаар тушаалаар баталсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуй нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ын дагуу анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болох бүрдлийг хангаагүй байсан болно.

Иймд “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын баталсан удирдамжийн дагуу Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 66 дугаар зүйл, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10.9.4, 10.9.8 дахь заалтын нөхцөл хангагдаагүй бөгөөд 2023 оны санхүүгийн аудитын “Хязгаарлалттай” дүгнэлт, үйлдвэрийн газрын Захирал Б.Наран-Идэр, Захиргаа, санхүүгийн албаны дарга Э.Мөнхболд болон бусад албан тушаалтан нар хууль тогтоомж, хөдөлмөрийн гэрээ, ажлын байрны тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлээгүй, санхүүгийн мэдээллийг үнэн зөв цаг тухайд нь гаргаж өгөөгүй тул хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцох нь зүйтэй гэж шийдвэрлэв гэжээ.

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР

